

Гепатит В-ийн тухай баримтууд

Таны мэдэх хэрэгтэй бүхэн 2-хон минутанд багтсан!

Гепатит В гэж юу вэ?

Гепатит В бол дэлхий дээрх хамгийн их тархсан элэгний ноцтой халдвар юм. Энэ нь элэгний эсүүдэд халдаж, элэгний хатуурал (сорвижилт), элэгний дутагдал, элэгний хорт хавдар үүсгэдэг гепатит В вирус (HBV)-ээр үүсгэгддэг.

Насанд хүрсэн ихэнх эрүүл хүмүүс халдвар авсан тохиолдолд халдвартай тэмцэж, цуснаасаа вирусыг цэвэрлэж чаддаг. Үүнд 6 сар хүртэл хугацаа орох бөгөөд энэ үед халдварлах чадвартай байдаг. Харамсалтай нь, нярай болон бага насны хүүхдүүд HBV-ийн халдвар авсан тохиолдолд архаг (насан туршийн) халдвар авах хамгийн өндөр эрсдэлтэй байдаг.

Насанд хүрэгчдийн 5-10%, хүүхдүүдийн 30-50%, нялх хүүхдийн 90% нь вирусыг даван туулах чадваргүй бөгөөд архаг халдвартай болно. Архаг халдвартай хүмүүсийн хувьд вирусыг бусдад дамжуулдаг (шинж тэмдэггүй байсан ч) ба хожим нь элэгний өвчин, элэгний хорт хавдар тусах эрсдэл өндөр байдаг.

Азаар, гепатит В-ийн халдвараас аюулгүй бөгөөд үр дүнтэй вакцины тусламжтай сэргийлж болно. Архаг гепатит В-тэй хүмүүст зориулсан үр дүнтэй эмчилгээнүүд ч мөн бий.

Гепатит В-ийн тухай тоон баримтууд

Дэлхийд:

- 1.5 сая хүн халдвар авсан
- Дэлхий даяар 296 сая хүн гепатит В-ийн архаг халдвартай байна.
- Элэгний хорт хавдар гэх мэт элэгний В вирусын хүндрэлээс болж жил бүр 820,000 хүн нас бардаг - 30 секунд тутамд 1 хүн

Америкийн Нэгдсэн Улсад:

- Дор хаяж 20,000 шинэ хүн халдвар авна
- 2,4 сая хүртэлх америкчууд гепатит В-ийн архаг халдвартай байна
- Олон мянган америкчууд элэгний хорт хавдар зэрэг В гепатит болон түүний хүндрэлээс болж нас барж байна

Гепатит В-с сэргийлж болох уу?

ТИЙМ! Аюулгүй, үр дүнтэй гепатит В-ийн вакцины талаар эмчээсээ асууж, өөрийгөө болон хайртай хүмүүсээ насан туршид нь хамгаалаарай. Center for Disease Control and Protection (CDC, буюу Өвчний Хяналт Хамгаалалтын Төвийн) зүгээс халдвар авах өндөр эрсдэлтэй бүх нярай, хүүхэд, 59 хүртэлх насны насанд хүрэгчид, 60 ба түүнээс дээш насны хүмүүст гепатит В-ийн вакцин хийлгэхийг зөвлөдөг. АНУ-аас гадна World Health Organization (WHO, буюу Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага)-аас бүх нярай, хүүхэд, 18 хүртэлх насны өсвөр насныхан, өндөр эрсдэлтэй насанд хүрэгчдэд вакцин хийлгэхийг зөвлөдөг. Насан туршийн хамгаалалттай болоход хэдхэн удаа тариулахад л хангалттай.

Гепатит В сан нь дэлхий даяар В гепатитаар өвчилсөн хүмүүсийн амьдралын чанарыг сайжруулах, эмчлэх арга замыг хайж олох зорилготой үндэсний ашгийн бус байгууллага юм.

Гепатит В хэрхэн халдварладаг вэ?

Гепатит В нь халдвартай цус, биеийн шингэнээр дамжин халдварладаг. Энэ нь цустай шууд харьцах, хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох, хууль бус мансууруулах бодис хэрэглэх, халдвартай эмэгтэйгээс нярайд жирэмсэн болон төрөх үед тохиолдож болно.

Гепатит В нь дараах байдлаар халдварладаг:

- Халдвартай цустай шууд
- харьцах Хамгаалалтгүй бэлгийн харьцаа
- Бохир эсвэл ариутгаагүй зүү (судсаар мансууруулах бодис хэрэглэх, шивээс/цоолтуур зүү)
- Халдвартай хүнтэй айлд амьдрах Халдвартай
- эхээс жирэмсэн болон төрөх үед нярай хүүхдэдээ дамжина
- Халдвартай хүнтэй сахлын машин, шүдний сойз, хумсны хутга, ээмэг, гоёл чимэглэлийг хуваалцах
- Халдвартай хүн хазуулах Хаа хамаагүй
- газрын шүдний эмч, эмч, үсчин нарын хэрэглэдэг ариутгаагүй багаж хэрэгсэл

Гепатит В нь дараах байдлаар тархдаггүй:

- Хацар эсвэл уруул дээр үнсэлцэх
- Ханиах, найтаах
- Тэврэх, гар атгах, барих зэрэг тохиолдлын холбоо
- Халдвартай хүний бэлдсэн хоол идэх эсвэл хамт хооллох



Хэн Гепатит В тусах хамгийн их эрсдэлтэй вэ?

- HBV-ийн халдвартай эхээс төрсөн хүүхдүүд
- Архаг халдвартай хүнтэй ойр дотно харилцаатай хүмүүс HBV тархсан улсаас үрчлэгдсэн хүүхдүүд
- 6 сарын дотор хамгаалалтгүй бэлгийн харьцаанд орсон эсвэл нэгээс олон бэлгийн хавьтагчтай болсон хүмүүс
- Бэлгийн замын халдварт өвчнөөр (БЗХӨ) оношлогдсон хүмүүс
- Эрэгтэйчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрчүүд
- Зүү, тариурыг хуваалцдаг хүмүүс
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчид, яаралтай тусламж үзүүлэгчид
- Бөөрний диализ хийлгэж буй хүмүүс
- Хорих анги, бүлгийн гэр гэх мэт байгууллагын орчинд ажиллаж, амьдардаг хүмүүс

Гепатит В-ийн нэмэлт эх сурвалжууд (англи хэл дээр)

- Гепатит В-ийн сан: <http://www.hepb.org>
- Вирус гепатитын CDC хэлтэс: <https://www.cdc.gov/hepatitis/>
- World Health Organization: <http://www.who.int/mediacentre/factsheets/fs204/en/>
- Дархлаажуулалтын үйл ажиллагааны нэгдэл: <http://www.immunize.org>